



МҮХАҮТ

7 ХОНОГИЙН ТОЙМ



2026.05.04 – 2026.05.08

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 26.06



ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ ХЭЛЭЛЦЭЭРҮҮД



МУ болон ЕАЭХ,
түүний гишүүн орнууд
хоорондын түр хэлэлцээр

АРТА

АРТА
Ази, Номхон далайн
худалдааны хэлэлцээр



АНУ-ын
хөнгөлөлтийн
ерөнхий систем



Европын холбооны
хөнгөлөлтийн
ерөнхий систем



Монгол - Японы
түншлэлийн
хэлэлцээр

JETRO

Худалдааг
дэмжих платформ
(TPP)



БТКУС-ийн
код



www.mongolchamber.mn

...

БУСАД НҮҮРЭНД



Санхүүгийн зах зээлийн эрүүл
тогтолцоог бүрдүүлэх бодлогын
асуудлаар ярилцлаа

...



"Хөгжлийн банкны нийгэм,
эдийн засаг дахь үүрэг, оролцоо"
хэлэлцүүлэг боллоо

...



Экспортыг дэмжих чиглэлээр хамтын
ажиллагаагаа идэвхжүүлэх талаар
уулзалт хийлээ

...




Бизнесийн орчин сайжирч байж
эдийн засагт бодит өсөлт ирнэ

...



Монгол Улсын Ерөнхий сайд хувийн
хэвшил болон хөрөнгө оруулагчидтай
уулзалт, хэлэлцүүлэг хийлээ

...



МҮХАҮТ Олон улсын ажил олгогчдын
байгууллагатай хамтын ажиллагаагаа
өргөжүүлэх талаар уулзалт хийлээ

...



Монголын экспортлогч аж ахуйн нэгжүүд
бараа бүтээгдэхүүнээ БНХАУ-ын
WYPS компанид танилцууллаа

...



Мэргэжлийн боловсролыг үндэсний
шилдэг 16 компанитай холбож,
залуусыг баталгаатай ажлын
байраар хангана

...



Салбарын шилдгүүдийн туршлагаа
хуваалцах талбар

...



Байгаль орчин, Нийгэм, Засаглал
(ESG)-ын сургагч багш бэлтгэх"
сургалт боллоо

...



Ажлын байран дахь сургалтын чанарыг
шинэ шатанд гаргах "мастер сургагчид"
бэлтгэгдлээ

...



БИЗНЕС САНАЛ: Хөгжил финанс ББСБ

...

7 ХОНОГИЙН ТОЙМ

Санхүүгийн зах зээлийн эрүүл тогтолцоог бүрдүүлэх бодлогын асуудлаар ярилцлаа



МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны Удирдах зөвлөлийн төлөөллийг хүлээн авч уулзан, санхүүгийн салбарын өрсөлдөх чадвар болон бизнесийн орчны тулгамдсан асуудлуудын талаар ярилцлаа.

"Хөгжлийн банкны нийгэм, эдийн засаг дахь үүрэг, оролцоо" хэлэлцүүлэг боллоо



Тус хэлэлцүүлэгт МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав оролцон тус банкны стратегийн ач холбогдлыг онцлон, Хөгжлийн банк нь үндэсний томоохон бүтээн байгуулалт болон экспортыг дэмжих төслүүдийг урт хугацаат санхүүжилтээр хангах замаар эдийн засгийн өсөлтийг түүчээлэх ёстойг дурдлаа.

Экспортыг дэмжих чиглэлээр хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх талаар уулзалт хийлээ



МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав, дэд захирал Ч.Баттулга нар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбаттай уулзаж, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих, ЖДҮ болон уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд бодлогын уялдааг хангах замаар бизнесийн орчныг сайжруулах асуудлаар санал солилцлоо.


Бизнесийн орчин сайжирч байж эдийн засагт бодит өсөлт ирнэ



Бизнес эрхлэгчид төрийн зүгээс бэлэн мөнгө бус, харин үйл ажиллагаагаа урт хугацаанд төлөвлөх боломжийг олгох тогтвортой хууль эрх зүй, бодлогын дэмжлэгийг хамгийн ихээр хүлээж байна. Энэхүү орчин сайжирч байж эдийн засагт бодит өсөлт ирнэ гэдгийг МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал энэ удаагийн ярилцлагадаа онцоллоо.

МҮХАҮТ Олон улсын ажил олгогчдын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар уулзалт хийлээ

МҮХАҮТ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Саруул Истанбул хотноо Олон Улсын Ажил Олгогчдын Байгууллагын (IOE) Ерөнхий нарийн бичгийн дарга Роберто Суарез Сантостой уулзаж, Монголын хувийн хэвшлийн дуу хоолойг олон улсад хүргэх, хөдөлмөр, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцлоо.



Монгол Улсын Ерөнхий сайд хувийн хэвшил болон хөрөнгө оруулагчидтай уулзалт, хэлэлцүүлэг хийлээ



Хэлэлцүүлгийн эхэнд Ерөнхий сайд "Эрх чөлөөний дөрвөн зам: дөрвөн чөлөөлөлт" сэдэвт танилцуулгыг хийж, МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор ААН-үүдийн гадаад, дотоодоос татсан зээлийн хүүгийн

татварыг 5 хувь болгон бууруулах буюу тэглэх санал гаргав. Мөн тэрээр Арилжааны хуулийн шинэчлэлтийн явцыг тодруулж, гэр хорооллыг орон сууцжуулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх хүсэлтийг уламжиллаа.

Мэргэжлийн боловсролыг үндэсний шилдэг 16 компанитай холбож, залуусыг баталгаатай ажлын байраар хангана



Политехник 33 коллежийг үндэсний тэргүүлэх 16 аж ахуйн нэгжийн менежментэд шилжүүлж, хамтын ажиллагааг эхлүүлснээр мэргэжлийн

боловсролын салбарт чанарын бодит өөрчлөлт гарч, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зөрүү арилах суурь нөхцөл бүрдэж байна.

Монголын экспортлогч аж ахуйн нэгжүүд бараа бүтээгдэхүүнээ БНХАУ-ын WYPS компанид танилцууллаа



МҮХАҮТ-ын Чөлөөт бүсийн нэгдсэн хөрөнгө оруулагчдын зөвлөлөөс БНХАУ-ын Ухань хотын "Wuhan Yangluo Port Service" (WYPS) компанийн



төлөөлөгчид болон дотоодын экспортлогч аж ахуйн нэгжүүдийн хамтарсан уулзалтыг зохион байгууллаа.

7 ХОНОГИЙН ТОЙМ

Салбарын шилдгүүдийн туршлагаа хуваалцах талбар



Chamber Podcast-ын энэ удаагийн дугаарт хөнгөн үйлдвэрийн салбарт технологи, инновацаараа манлайлагч "Чиглэл" ХХК-ийн амжилтын түүх, баялаг туршлагыг онцлон хүргэж байна.

Үндэсний үйлдвэрлэлийг дэлхийн стандартад хүргэж буй тэдний бизнесийн алсын хараа, салбарын хөгжлийн талаарх сонирхолтой яриаг хүлээн авч үзээрэй.



Танд дараах Шугамын эрхтэй зээлийн эрхээр нэг удаа гэрээ байгуулан тогтоосон эрхийн хэмжээнд зээл авах, төлөх харилцааг хэдэн ч удаа үүсгэж болно.



БИЗНЕСИЙН ЗЭЭЛИЙН ШУГАМ

ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ	ЗЭЭЛИЙН ХҮҮ	АШИГЛААГУЙ ҮЛДЭГДЭЛД ТООЦОХ ХҮҮ	ЗЭЭЛИЙН ХУГАЦАА
300 САЯ ₮ ХҮРТЭЛ	2.7%	0.4%	12-48 САР ХҮРТЭЛ

БИЗНЕС ФОРУМ БА ҮЗЭСГЭЛЭНГҮҮД



1. "Монгол-Чехийн бизнес уулзалт, аялал" /2026.05.12-20/ Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо "Монгол-Чехийн бизнес уулзалт, аялал" арга хэмжээг зохион байгуулна.

2. Монгол-ОХУ-ын Эрхүү мужийн бизнес эрхлэгчидтэй хийх B2B уулзалтад /2026.05.19/ Эрхүү мужийн барилга, ноос ноолуур, банк санхүү, оёдол, даавуу үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд оролцоно.



3. Чанарын хяналт ба баталгаажуулалт (QA/QC) сургалт /2026.05.26-27/

4. Лабораторийн ажилтны ур чадварыг хөгжүүлэх сургалт №1



5. "Bazaar Berlin 2026" /11.04-08/: ХБНГУ-ын Берлин хотноо болох дэлхийн соёл, гар урлалын үзэсгэлэнд оролцохыг урьж байна.



6. KIDS EXPO 2026 эх, үрсийн баярт зориулсан үзэсгэлэнд оролцогчдын бүртгэл явагдаж байна /2026.05.29-06.01/



7. "Envex 2026" олон улсын үзэсгэлэнд урьж байна /2026.05.19 – 05.23/

Байгаль орчны технологи, ногоон эрчим хүчний салбарын хамгийн том цугларалт "ENVEX 2026" 47 дахь удаагийн үзэсгэлэн Сөүл хотноо зохион байгуулагдах гэж байна.



8. ШЭНЬЖЭН & ШАНХАЙ I БИЗНЕС АЯЛАЛ 2026 /2026.05.21-28/ AI · Финтек · Ногоон Технологи Монголын залуу бизнес эрхлэгчид та бүхнийг Ази тивийн хамгийн хурдацтай хөгжиж буй хотуудад очиж, ирээдүйн бизнесийн чиг хандлагыг биечлэн мэдэрч, дэлхийн хэмжээний туршлагаас суралцан, бизнесийнхээ дараагийн шатыг хамтдаа тодорхойлохыг урьж байна!

